



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 5/38

Чингис хот

Н.Үнэнбатыг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.10, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.3.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.4-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Норовын Үнэнбат нь хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, тус газрын 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 05/8834 тоот албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

С.Нямдаваа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

М.Дэлгэрзаяа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн

Л.Оюунтуяа

Орон нутгийн өмчийн газрын нягтлан
бодогч

3. Н.Үнэнбатад Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг тооцож олгохыг Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч /Л.Оюунтуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Н.Үнэнбатад үүрэг болгосугай.

5. Н.Үнэнбатад томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ